



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 696

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 47,000,000.00 (дөчин долоон сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ц.Гантөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201591

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн  
696 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "МАЛ  
ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИ" УЛСЫН ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Хьюндай Старекс, микробус, 30-29 УНВ, КМJWA37JBCU407860	47,000,000.00	10,000,000.00	3
Нийт дүн		47,000,000.00	10,000,000.00	-
		(дөчин долоон сая)	(арван сая)	-